



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/1649

Улаанбаатар хот

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Иргэний хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар баталсан “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар”-ын зарим заалтыг хавсралт ёсоор өөрчилсүгэй.

2. Дараах арга хэмжээг энэ захирамжийн хавсралтад заасан Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарт даалгасугай:

2.1. байгууллагын дүрэм, гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, 2023 оны нэгдүгээр улиралд багтаан батлуулах;

2.2. тухайн албан тушаалын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд Төрийн албаны зөвлөлөөр хянуулж, баталсан Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг өөрчлөхгүй байх;

2.3. шилжин ирж ажиллах төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шуурхай баталгаажуулах арга хэмжээг зохих журмын дагуу зохион байгуулах;

2.4. Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах.

3. Шилжин ажиллах төрийн захиргааны албан хаагчдын цалин болон бусад урсгал зардлыг нийслэлийн 2023 оны төсвийн тодотгол хийгдэх хүртэл батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т даалгасугай.

4.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хяналт шалгалтын чиг үүргийг гүйцэтгэх албан хаагчдыг ажлын байраар хангаж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/1105 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ захирамжийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
 16 дугаар сарын 30-ны өдрийн
 захирамжийн
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЗАРИМ
 АГЕНТЛАГУУДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
 БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР

д/д	Хэрэгжүүлэгч агентлагуудын нэр	Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар	1.Захиргаа, санхүүгийн хэлтэс 2.Бодлогын хэрэгжилтийн хэлтэс 3.Агаарын чанарын хэмжилт зохион байгуулалтын хэлтэс 4.Хяналт шалгалтын хэлтэс	48 хүртэл, үүнээс Дарга-1
4	Байгаль орчны газар (Зуслангийн товчоотой)	1.Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 2.Ойн хэлтэс 3.Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтэс 4.Хөрсний бохирдол, доройтлыг бууруулах хэлтэс 5.Биологийн олон янз байдлыг хамгаалах хэлтэс 6.Зуслангийн товчоо 7.Хяналтын хэлтэс	100 хүртэл, үүнээс Дарга-1
9	Боловсролын газар	1. Захиргааны хэлтэс 2.Боловсролын бодлого, багшийн хөгжлийн хэлтэс 3.Боловсролын чанар, гүйцэтгэлийн үнэлгээний хэлтэс 4.Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэлтэс 5.Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын хэлтэс 6.Боловсролын хяналтын хэлтэс 7.Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтэс	78 хүртэл, үүнээс Дарга-1
19	Хүнс, хөдөө аж ахуйн газар	1.Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 2.Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс 3.Газар тариалан, мал аж ахуйн хэлтэс (Мал үржлийн албатай) 4.Хяналтын хэлтэс	83 хүртэл, үүнээс Дарга-1
21	Эрүүл мэндийн газар	1.Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 2.Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 3.Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс 4.Статистик мэдээлэл, цахим эрүүл мэндийн хэлтэс (Цахим үйлчилгээ, анхан шатны эрүүл мэндийн алба)	120 хүртэл, үүнээс Дарга-1

		<p>5.Чанар, эрүүл мэндийн хяналт зохицуулалтын хэлтэс (дүүргийн эрүүл мэндийн хяналт, зохицуулалтын албатай)</p> <p>6.Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс</p> <p>7.Эрүүл мэндийг дэмжих, нийтийн эрүүл мэндийн хэлтэс</p> <p>8.Эмнэлгийн тусламжийн хэлтэс</p>	
22	Хотын стандарт, хяналтын газар	<p>1.Захиргаа, санхүүгийн хэлтэс</p> <p>2.Дотоод хяналт, шинжилгээний хэлтэс</p> <p>3.Хотын хөгжлийн стандартын хэлтэс</p> <p>4.Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтэс</p> <p>5.Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс</p> <p>6.Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс</p> <p>7.Байгаль орчны стандартын хэлтэс</p> <p>8.Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтэс</p>	105 хүртэл, үүнээс Дарга-1